

## НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

### НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХУУДСАНД БҮРТГЭГДСЭН АЛБАН ТУШААЛТАД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН (2026 оны 01 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 26-ийг хүртэл)

2025 оны 5 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Нийслэлийн [erp.ulaanbaatar.mn](http://erp.ulaanbaatar.mn) цахим хуудсанд бүртгэгдсэн албан тушаалтадг аргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 226 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал бүртгэгдсэнээс буюу 99.00 226% хуулийн хугацаанд судалж, шалган шийдвэрлэсэн. Өргөдөл гомдол шийдвэрлэх шатанд 2 өргөдөл, гомдол байна

#### 1. Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо

Ангилал		Нийт		Шийдвэрлэх шатандаа байгаа						Шийдвэрлэж хариу өгсөн					
				Хугацаандаа байгаа		Хугацаа хэтэрсэн		Бүгд		Хугацаандаа шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Бүгд	
		1=4+7		2		3		4=2+3		5		6		7=5+6	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1800-1200 операатораас	Тоо	21	100	0	0.00	0	0.00	0	0.00	21	100	0	0.00	21	100
	Хувь	9.21	9.21	0	0.00	0	0.00	0	0.00	9.21	9.21	0	0.00	9.21	9.21
Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн	Тоо	207	100	2	0.97	0	0.00	0	0.00	205	99.03	0	0.00	205	99.03
	Хувь	90.79	90.79	100.0	0.88	0	0.00	0	0.00	90.71	89.91	0	0.00	90.71	89.91
Нийт	Тоо	228	100.0	2	0.00	0	0.00	2	0.00	226	99.0	0	0.00	226	99.0
	Хувь	100.0	100.0	100.0	0.00	0	0.00	100.0	0.00	100.0	99.0	0	0.00	100.0	99.0

## 2.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлан

	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл
оны эхний хагас жил 2025	0	23	20	404
оны эхний хагас жил 2026	0	12	18	226

Дүгнэлт:2025 оны эхний хагаст 412 өргөдөл, гомдол ирсэн байсныг энэ жилд 228 ирсэнийг харьцуулахад 176-аар буурсан байна,энэ нь хүний нөөцийн албанд эмч, ажилчдаас ирдэг хүсэлт цуг байсантай холбоотой байсан.



## 3.Хариу өгсөн хэлбэрийн тайлан

Д/д	Хариу өгсөн хэлбэр	Тоо
1	Программ хангамж+ Мессежээр хариу өгсөн	211
2	Программ хангамж+ Мессеж+утсаар хариу өгсөн	15

## 4.Шийдвэрлэсэн байдал

Д/д	Ангилал	Тоо
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	222
2	Боломжгүй тухай хариу өгсөн	4

## 5.Өргөдөл, гомдлын төрлийн тайлан

Д/д	Байгууллага	Хүсэлт		Гомдол		Талархал		Санал		Нийт
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
1	2025 оны эхний хагас жил	49	12.12	13	3.21	341	84.40	1	0.24	404
2	2026 оны эхний хагас жил	2	0.88	17	7.45	208	91.22	1	0.43	228

Дүгнэлт:Өргөдөл, гомдлын төрлийн тайланг уурд оны мөн үетэй харьцуулж, графикаар гаргаж үзсэн. Хүсэлт 49-өөс 2 болж буурсан нь хүний нөөцийн албанд ирдэг байсан эмч ажилчдаас, тэдний гэр бүлээс гаргасан хүсэлт энэ жилээс тусдаа бүртгэгддэг болсонтой холбоотой буурсан. Гомдол 13 байсан бол 17 болж 4-өөр өссөн боловч гомдлын утгыг харахад ноцтой гомдлууд байгаагүй. Талархал 341-ээс 208 байгаа нь 133 тохиолдлоор буурсан боловч нийт өргөдөл гомдлын 91.22% байгаа нь урд оноос 6.82% өссөн өндөр хэвээр байна.



### 6.Өргөдөл, гомдлын хандалтын тайлан

Д/д	Ангилал	Өргөдөл гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Яаралтай тусламж, үйлчилгээний тухай	201	88.16
2	Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	9	3.95
3	Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тухай	8	3.51
4	Ажлын сахилга хариуцлагын тухай	4	1.75
5	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай	3	1.32
6	Түргэн тусламжийн дуудлага хүлээн авахгүй байгаа тухай /Амбулатор, яаралтайгаар үзүүлэх/	1	0.44
7	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	1	0.44
8	Баригдаж буй барилга, байгууламж чанарын шаардлага хангаж байгаа эсэх тухай	1	0.44
14	Нийт өргөдөл, гомдлын дүн	228	100.0

## Нэгдсэн тайлан албан хаагчаар.7

Ангилал		Нийт		Шийдвэрлэх шатандаа байгаа						Шийдвэрлэж хариу өгсөн							
				Хугацаандаа байгаа		Хугацаа хэтэрсэн		Бүгд		Хугацаандаа шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Бүгд			
				1=4+7		2		3		4=2+3		5		6		7=5+6	
				Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
А.Алтанзагас	Тоо	228	100.0	2	0.88	0	0.00	226	99.12	226	99.12	0	0.00	226	99.12		
Нийт	Тоо	228	100.0	2	0.88	0	0.00	226	99.12	226	99.12	0	0.00	226	99.12		

## 8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан (байгууллагаар)

Ангилал		Нийт		Шийдвэрлэх шатандаа байгаа						Шийдвэрлэж хариу өгсөн							
				Хугацаандаа байгаа		Хугацаа хэтэрсэн		Бүгд		Хугацаандаа шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Бүгд			
				1=4+7		2		3		4=2+3		5		6		7=5+6	
				Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийслэлийн Түргэн тусламжийн төв		228	100.0	2	0.88	0	0.00	2	0.88	226	99.12	0	0.00	226	99.12		

## 9. Дундаж хугацааны тайлан

Д/д	Байгууллагын нэр	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа			Өргөдөл гомдлын тоо
		Хоног	Цаг	Минут	
1	Захиргаа	0	12	18	228
	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	0	12	18	228

## Зөрчлийн тоон тайлан.10

Д/д	Байгууллагын нэр	Зөрчлийн төрөл				Нийт
		Буцаалтыг 3 хоног хийгээгүй	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	
1	А.Алтанзагас	0	1	0	2	3
2	А.Алтанзагас	0	0	0	0	0

Зөрчлийн тоон үзүүлэлт 2025 оны эхний хагас жилд 3 байсан бол 2026 оны эхний хагас жилд зөрчилгүй ажилласан сайн тал харагдаж байна.

Албан тушаалтад гаргасан иргэдээс ирэх өргөдөл, гомдлыг бууруулах чиглэлээр хийх байгууллагын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 8 зорилттой, 35 ажил хийхээр ЭМТҮЧАБА-аас боловсруулан, даргаар хянуулж 04 дүгээр сарын 13-нд батлуулган нийт ахлах эмч, албадад танилцуулсан.

**ЗОРИЛТ.1 ИРГЭДЭЭС БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХУУЛИЙН ХУГАЦААНД ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ чиглэлээр:**

1.Нийслэлийн цахим <https://erp.ulaanbaatar.mn/> дстоод үйл ажиллагааны нэгдсэн удирдлагын системд бүртгэгдсэн гаргасан 228 өргөдөл, гомдлыг өдөрт нь багтаан хүлээн авч, 0 хоног, 12 цаг, 18 минутанд хугацаанд шийдвэрлэн иргэнд хариуг өгч, зөрчилгүй ажиллаж, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан.

ЭМТҮЧАБА-аас боловсруулан, даргаар хянуулж 04 дүгээр сарын 13-нд батлуулган нийт ахлах эмч, албадад танилцуулсан.

№	Төрөл	Хугацаа	Төлөв	Тайлбар
1	Өргөдөл	0 хоног, 12 цаг, 18 минут	100%	Хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан.
2	Гомдол	0 хоног, 12 цаг, 18 минут	100%	Хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан.




2.Тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдлын дагуу тохиолдлыг нийт эмч нарт танилцуулан, сар бүр нийт 4 удаа тусламж үйлчилгээ, гомдол, тохиолдолд суурилсан хэлэлцүүлгийг зохион байгуулж хэвшсэн. Тус хурлаар гомдлыг танилцуулж, зөвлөмж боловсруулж, сургалтыг ЭМТҮЧАБА-аас зохион байгуулан ажиллаж байна.



3.Хүүхдийн дуудлага хүлээн авах нэгдсэн нэгжийн утсан харилцааны алдаатай холбоотой 3 гомдлын дагуу 3 ээлжийн нийт 27 эмч, сувилагч нартай

ЁЗХХ-ны дарга Д.Дариймааттай хамтран уулзалт хэлэлцүүлэг 3-р сарын 4-6-ны өдрүүдэд хийж, ХЭАЯТ-ийн чиглэлээр сорил авч, МШУТ-өөс албан бичгээр гарган авсан сүүлийн 3 гомдлын ярианы бичлэгийг өөрсдөд нь сонгож, зөвлөмж, өгч ажилласан. 100% бүгд хамрагдсан. Баримтжуулж авсан. Хэлэлцүүлэг, уулзалтаас гарсан зөвлөмж №7 боловсруулж, судлуулж ажилласан.





4. Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй өөр байгууллагын 3 өргөдөл, гомдлыг буцаах, шилжүүлэх ажлыг ажлын 8 цагт багтаан шийдвэрлэсэн.

5. Өргөдөл гомдолд дурдсан төрийн болон албаны, хувь хүний нууцыг задруулахгүй байх, хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.

6. Өргөдөл гомдол шийдвэрлэхдээ байгууллагын дотоод журам болон холбогдох хууль тогтоомжид заасан зөрчлийг удаа дараа гаргасан, эсхүл ноцтой зөрчил гаргасан бол холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцох хүрээнд 1 эмчийн ажлын байрыг сэлгэн ажиллуулж, нийт эмч нарт 3 өглөө мэдээлэл хүргэж, тушаалыг танилцуулж ажилласан.

7. Иргэдээс, НЭМГ, ЭМЯ болон бусад байгууллагаас хандаж буй амаар, бичгээр, цахим сүлжээгээр, болон албаны утсаар ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах, бүртгэн бүх талаас нь судалж хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэх, иргэнтэй холбогдож шийдвэрлэлтийг танилцуулах, өргөдөл гомдол хүлээн авах утсыг нээлттэй байлгах, ил тод байдлыг хангах, иргэдтэй уулзалт хийх хуваарь гаргаж чиглэлээр [Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн албан ёсны хуудас](#)", [www.103.ub.gov.mn](http://www.103.ub.gov.mn) төвийн цахим хуудаснуудад иргэдээс ирэх өргөдөл, гомдол, санал хүсэлтийг нээлттэй хүлээн авахаар байгууллагын цахим хуудсанд салбар төвүүдийн утас, алба нэгжийн өргөдөл гомдол хүлээн авах утсыг байршуулан ажилласан байна.

- Утас: 321811 /Ажлын цагаар/
- Түргэн тусламжийн дуудлагын утас Төв салбар: 103, 70120103 /24 цагаар/
- Баянзүрх салбар - 70158083
- Сонгинохайрхан салбар - 70170103
- Хан-Уул салбар - 70040103
- Чингэлтэй салбар - 70121103
- Өргөдөл гомдол хүлээн авах утас: 11327485, 70193623 /Хүний нөөцийн алба/
- ЭМТҮЧАБ Албаны утас: 11-330103
- Засгийн газрын 11-11 төвөөс 17
- Албаны утсаар 2
- Иргэн биеэр 1
- Салбарын утсаар 3 тус тус санал, хүсэлт гомдол бүртгэгдсэн байна.

Ирсэн гомдлыг үзэхэд:

2026 оны эхний хагас жилийн байдлаар талархал давхардсан тоогоор 175 эмч, ахлах эмч, 111 жолооч, 1 сувилагч нарын давхардсан тоогоор 443 талархал ирсэн байна.

The screenshot displays the website for the 103 emergency service. At the top, there is a navigation menu with links for 'ХӨСӨЛ', 'БЭЛЭГЛЭГЭЭ', 'ТҮҮЭН ЗАМНАЛ', 'МЭДЭЭЛЭЛ', 'ХҮҮРЬСЭХ ЭЙ', 'НЭГТӨД БАЙДАЛ', 'ДИЛОН ДАНС', 'ХӨЛӨСӨ БАРИН', and a user profile icon with the number '32101'. Below the navigation, there are two main content areas with blue buttons for 'БАУВ@GMAIL.COM' and 'SUOER@GMAIL.COM'. A central banner contains Mongolian text: 'Хүн ч мэддэг цахууны алба /албан нөхцөлөөр / хэргийг зогсооход хөл дээрээ босгоод гарлаа. Төний өвчт өлсөнд эрүүл мэндийг хүсэж, Эргэн сэвсэн үйлс нь дэлгэрч байг'. Below this, there are logos for 'ХАМТРАГЧИ БАЙГУУЛЛАГУУД' and several partner organizations including 'ДИРЛЭГЭЭНИЙ АЛБ', 'БЭРЭГ', 'ЭМД', and 'УЛААНБААТАР'. At the bottom, a blue footer contains contact details: 'Цахим хуудас' (with links to 'Мая: 103@103.mn', 'web: 103center.mn', 'Facebook: 103center', and 'Twitter: 103center'), 'Салбар төөгүтэй холбоо барих 24/7' (with phone numbers for 'Төв салбар: 70120103', 'Баянзүрх салбар: 70158083', 'Сонгинохайрхан салбар: 70170103', 'Хан-Уул салбар: 70040103', and 'Чингэлтэй салбар: 70121103'), 'Санал, гомдол хүлээж авах' (with phone numbers '11-330103, 11-327485, 11321811'), and 'Дуудлага өгөх дугаар' (with a large '103' icon).



- Тусламж үйлчилгээний алдаа 6 буюу 35.2%.
- Ёс зүйн хэм хэмжээ, харилцааны алдаа 7 буюу 41.1%. Үүнээс “Хүүхдийн дуудлага хүлээн авах нэгдсэн нэгж”-ийн утсан харилцааны алдаа 4 буюу 23.5%.
- Автобаазын үйлчилгээтэй холбоотой гомдол -1 буюу 5.8%
- Тусламж үйлчилгээний дагуу үйлчилсэн, үндэслэлгүй 2 буюу 11.7%
  - Яаралтай бус хүүхдийн дуудлагад ар гэр хаягаа зөв өгөөгүй, буруу хаяг дээр очоод утсаар залгахад утсаа иргэн авахгүй, таслаад, шаардлага тавьж иргэний үүргээ зөв биелүүлэх тайлбарыг тавихад иргэн эсрэгээр эмчийн дүрс бичлэгийг авч, цахимд байршуулна гэж сүрдүүлж, эмч иргэнийг цагдаад бүртгүүлэн ажил үүргээ гүйцэтгэж явцад саад учруулсан гэж бичлэгийг устгуулсан.
  - Дотрын өвчний оноштой иргэнд газар дээрх тусламж үзүүлж, харьяа дүүргийн эмнэлэгт хүргэх заалттай хүргэх гэхэд харьяаллын бус эмнэлэгт хэвтэнэ гэж зөрж гомдол гаргасан тохиолдол.)

Иргэн гомдлоо буцаасан 1 буюу 5.8%. (30 настай иргэний ээж, үйлчлүүлэгчид антибиотик бичиж өгөхийг шаардсан, дуудлагад очсон эмч харьяа ӨЭМТ-ийн эмчээс хөнгөлөлттэй бичүүлж, цаашид хянуулж үйлчлүүлэхийг зөвлөхөд гомдол гаргасан ба үйлчлүүлэгчийн ээж, эмчтэй холбогдон учир байдлаа ойлгон гомдлоо буцаасан тохиолдол.)

Дүгнэлт:

- **Тусламж үйлчилгээтэй холбоотой 6 алдаанаас 2 гомдол нь 1 иргэнээс давхар орж ирсэн гомдол давтагдсан.** Бусад 4 нь мөр мултрал оруулаагүй, давтан дуудлагаар эмнэлэг хүргээгүй, нас баралт, хүүхдэд өгөх эмийн зөвлөгөө хангалтгүй, зөвлөгөө хангалтгүй гомдол байсан.
- **Ёс зүйн хэм хэмжээ, харилцааны алдаа 7 алдаанаас 4 нь ХДХАНН-ийн иргэнтэй утсаар харилцахдаа алдаа гаргасан байсан бол 3 нь хаяг олдохгүй тодорхойгүй байсан, иргэнтэй зөв харьцаж, зөвлөгөө хангалттай өгөөгүй, зөв ойлгуулж, ойлголцож чадахгүй гэх мэт засагдаж болох асуудлууд байсан.** Дээр нь хэцүү үйлчлүүлэгч нар байсан.
- ТС-ын 1 эмчид ёс зүйн болон тусламж үйлчилгээний 2 гомдол орж ирсэн.
- Нийт 17 гомдлоос 2 нь үндэслэлгүй буюу тусламж үйлчилгээний дагуу үйлчилсэн, 1 гомдол буцсан, 1 гомдол давтагдсан гэхээр 4 нь буюу 23.5% хэрэгцээгүй, шаардлагагүй байсан.

**ЗОРИЛТ.2 ИРГЭД, БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ чиглэлээр:**

1.Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол бүрд цахим болон цаасан бүртгэл хөтлөлтийг 03-02 коджуулж дугаарлан, хавтас нээн баримтжуулж хэвшсэн.

2. Өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу арга хэмжээ авах байгууллагын журмыг шинэчлэн, хянуулах шатандаа явж байна.

3.Гомдол бууруулах хүрээнд байгууллагын чанарын албаны 4, чанарын орон тооны бус гишүүдийн хамтарсан хурлыг 7 удаа зохион байгуулж, хурлаас гаран шийдвэрт тулгуурлан, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх хугацаат үүрэг даалгавар өгч ажилласан.

4.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны явцад дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс үүсэж болох эрсдэлийг эрэмбэлж, тодорхойлж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, бусад алба нэгжтэй хамтран ажиллаж гомдлыг бууруулах чиглэлээр ЭМТҮЧАБА-ны эрсдэлийн менежер гомдолд тулгуурласан эрсдэлийн үнэлгээ хийж ажилласан. Үүнийг албаны даргад танилцуулсан.



**ЗОРИЛТ 3. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ, ЭМНЭЛ ЗҮЙН УДИРДАМЖ, ЗААВАР, СТАНДАРТ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ чиглэлээр:**


1.МУ-ын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөх стандарт, ЭМС-ын тушаалтай заавар, удирдамжийн шинэчлэгдсэн жагсаалтыг гарган байршуулсан. Шинээр гарсан стандарт удирдамж, ЭЗЗ-ийг файлаар оруулж, эмч нарт мэдээлэл өгсөн.

2.Орос улсын эмнэл зүйн платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх, түргэн тусламжийн үйлчилгээний алгоритмыг боловсруулах хянах шатандаа явж байна.

3.Утсан харилцааны гомдлыг бууруулах, хүүхдийн дуудлага хүлээн авах нэгдсэн нэгжтэй уулзалт, хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулж, ярианы бичлэгийг сонсон, 2 зөвлөмж боловсруулан судлуулж ажилласан байна. Зорилт-1-ын 3-т дэлгэрэнгүй оруулсан.

**ЗОРИЛТ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН БОЛОН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ чиглэлээр:**

1.Үйлчлүүлэгчийн аюулгүй тээвэрлэлт, тээвэрлэлтийн тусламж үйлчилгээ сайжруулах ЭМС-ын А/220 хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах сургалтын 2-р сарын 16-нд ЭМТҮЧАБА-ны дарга нийт эмч нарт орсон. Мөн 4, 5-р сард ТҮХОД, ХАБ-ын ажилтан н.Дэлгэрбаяр нар автобааз дээр нийт 125 жолооч нарт бодит машин дээр үзүүлэн сургалт ыг зохион байгуулсан.





2. Гардан үйлдлийн стандартыг дагаж мөрдөх, гардан үйлдэлтэй холбоотой гомдлыг бууруулах ажлыг зохион байгуулах зорилгоор 5 салбарт 4-5-р сард зохион байгуулсан. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, аюулгүй тарилга хийх, эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлийн стандартын дагуу сургалт зохион байгуулсан. Нийт 135 эмч нар хамрагдан ур чадвараа сайжруулсан.



3.Эмийн аюулгүй байдлыг сайжруулах, өндөр эрсдэлтэй эм / мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, тариа зэрэг/-ийн аюулгүй байдлыг хангах, дотоод хяналт хийх чиглэлээр салбарт ЭМТҮЧАБА-ны менежерүүд, дотоод хяналтын ажилтантай, эмийн сангийн ажилтантай хамтран 3 удаа, салбар дотроо 2 удаа хийж ажлыг сайжруулсан.

Эмийн аюулгүй байдлаар салбар бүрийн 15 ээлж, дотроо сургалтыг зохион байгуулсан.



### ЗОРИЛТ 5. ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЧИГЛЭЛЭЭР:

1.Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч нарын сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч, судалгааны тайланг дүгнэж, удирдлагад мэдээлэх, саналын дагуу олон талт ажлыг зохион байгуулахаар Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг QR кодоор уншуулан 1313.mn сайтад бүртгэн ажиллаж байна. Цаасаар 6 дүүргийн 120 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Дүгнэлтийг удирдлагад танилцуулсан.

2.Тусламж үйлчилгээний явцад үүсэх 35 тохиолдлыг бүртгэн, хариу арга хэмжээ авч, тохиолдлын сан үүсгэн, хэрэгжилтийг хангаж ажилласан, хавтасжуулсан.

3.Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хүрээнд төр, ТББ, мэргэжлийн нийгэмлэг, иргэнтэй хамтран ажиллах чиглэлээр Дэлхийн эмч нарын өдрөөр эмч нараа алдаршуулан, Витавит, абсалют, цэцэг хүргэлтийн байгууллагатай хамтран ажилласан.

НИТХ-ын дарга, албаараа ирэн 1 өдөр танилцан, 5 эмнэлгийн автомашин бэлэглэсэн. Тусламж үйлчилгээндээ хэрэглэж байна. хоногт 43-45 машин 24 цагаар гарч байсан бол 51-53 болж, 20 минутын очилт 18.9% буурсан сайн үзүүлэлт гарсан. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Нийслэлийн Засаг даргын орлогч А.Амартүвшин, НЭМГ-ын дарга Н.Наранбаатар нар Нийслэлийн түргэн тусламжийн төвд түргэн тусламжийн 5 автомашиныг хүлээлгэн өглөө. Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлтийг үе шаттай хийснээр Нийслэлийн иргэдэд тусламж үйлчилгээг хүлээгдэлгүй, түргэн шуурхай хүргэх боломж бүрдэнэ.

2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр НИТХурлын дарга А.Баяр, ДЭМБ-н суурин төлөөлөгч Сокорро Эскаланте, Нэгдсэн өвчний хяналтын зохицуулагч Шалала Ахмадова, Эрүүл мэндийн тогтолцооны техникийн ажилтан Шибата Огуса, Түншлэл, гадаад харилцааны асуудал хариуцсан ажилтан Фернандо Галиндо нар НТТТөвд ажиллалаа. Энэ үеэр Түргэн тусламжийн эмч нарыг чадавхжуулах, дутагдалтай байгаа автомашиныг шийдвэрлэх, үйл ажиллагааны менежментийн талаар санал солилцож цаашид хамтран ажиллахаар төлөвлөсөн.

3-сарын 19-нд Нийслэлийн ИТХ-ын дарга А.Баяр НИТХ-ын төлөөлөгч Д.Отгонсүрэнгийн хамтаар ХБНГУ-ын Эмнэлгийн эрүүл ахуйн нийгэмлэг (DGKH)-ийн дэд ерөнхийлөгч, профессор Вальтер Поппыг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр профессор Вальтер Попп Монгол улсад эмнэлгийн эрүүл ахуй ба яаралтай түргэн тусламж төслийг 2010 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн үр нөлөөгөөр 15 жилийн хугацаанд эмнэлгийн эрүүл ахуй эрс сайжирч, гепатитын халдварыг бууруулах, үр нөлөөтэй зөв вакцинжуулах, гарын халдваржүүлэлт зэрэг ажлууд сайжирсан гэлээ.

Цаашид оношлуурын дурангийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, шүдний эмнэлгүүдийн аппарат, тоног төхөөрөмжийн халдваргүйжүүлэлтийг сайжруулах шаардлага байгааг онцоллоо. Мөн олон эмийн дасалтай бактерийн тархалтыг хэрхэх талаар ХБНГУ-аас багш, эрдэмтэн докторууд ирж сургалтуудыг хийсэн талаар танилцуулав.

Мөн Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн менежмент, эмч ажилчдын чадавхыг сайжруулж сургах асуудлаар санал солилцов. Талууд зөвхөн эрүүл мэндийн салбараар тогтохгүй өргөн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар ярилцсан.



Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, МШУТ-ийн Шуурхай удирдлагын хэлтэс (103)-ийн дарга, хошууч Д.Төгөлдөр нар төвийн үйл ажиллагаатай танилцаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

5-р сарын 22-нд Япон улсын Сайтама Анагаах Ухааны их сургуулийн профессор Иноүе Нобуаки, Кавагое ротари клубийн 2026-2027 оны ерөнхийлөгч Мамору Номизо, Тецуяа Хироши, Койчи Кионо нар төвийн үйл ажиллагаатай ажиллагаатай танилцлаа. Төвийн дарга С.Ариунболд Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч санал солилцлоо. Цаашид Монгол, Япон хоёр улсын эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, түргэн тусламжийн тогтолцооны чанар, чадавхыг сайжруулахад хамтран ажиллах болно.



4.Эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй сайжруулах хүрээнд байгууллагын салбар, ээлжийн чанарын багуудтай хамтран чанарын аян, өдөрлөг, эмнэл зүйн сургалт, ярилцлага, хэлэлцүүлэг тогтмол хийх, чанарыг тасралтгүй сайжруулах арга хэрэгслийг хэвшүүлэх зорилгоор Гомдол бууруулах чиглэлээр, эмнэлгийн тусламжийг сайжруулах хүрээнд дараах аян, өдөрлөг, эмнэл зүйн сургалт, ярилцлага, хэлэлцүүлгийг тасралтгүй хийж байна. Үүнд:

- Аян- 3
- Өдөрлөг - 6
- Эмнэл зүйн сургалт - 12
- Хэлэлцүүлэг - 6
- Чанарын хурал -2
- Дотоод сургалт - 14 хоног тутам
- Дотоод хяналт, сургалт мэдээлэл, нийтдээ 12 зөвлөмж боловсруулан нийт эмч нарт мэдээлж ажилласнаар тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол өмнөх онтой харьцуулахад 27%-иар буурсан.
- Сар бүр тусламж үйлчилгээ, гомдол, тохиолдолд суурилсан хэлэлцүүлгийг зохион байгуулж хэвшсэн. Тус хурлаар гомдлыг танилцуулж, зөвлөмж боловсруулж, сургалтыг

5.Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт болон, НЭМ-ийн Үндэсний хөтөлбөрийн дагуух ажлын үр дүнг тооцон ажиллах, иргэдийн эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг тасралтгүй зохион байгуулах чиглэлээр байгууллагын төлөвлөгөөний дагуу

тогтмол [Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн албан ёсны хуудас](http://www.103.ub.gov.mn)", [www.103.ub.gov.mn](http://www.103.ub.gov.mn) төвийн цахим хуудаснуудад 7 хоног тутамд 12-20 хүртэл мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмж, сэрэмжлүүлэг, анхааруулга зэргийг тасралтгүй хүргэж ажилласан.

2026 оны 02 сарын 04 өдөр Дугаар 41 Монгол Улсын засгийн газрын тогтоолын 1 дүгээр хавсралт Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам, Монгол Улсын стандарт "Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285"-д нийцүүлэн мөн Веб сайт (103.ub.gov.mn) болон facebook пэйж хуудас, инстаграммд байгууллагын цаг үетэй холбоотой мэдээллийг "Шил ажиллагаа" системээр нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6, 8, 10 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэл хариуцагч байгууллагууд нь ил тод, нээлттэй байлгах 87 төрлийн мэдээллийг 2026 оны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ([shilen.gov.mn](http://shilen.gov.mn)) олон нийтэд нээлттэй харуулах шаардлагын дагуу Содон Солушн ХХК-аар 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс байгууллагын веб хуудсыг шинэчлэн хийснээр хурд сайжирч, хандалт ихэссэн байна.

Өмнө нь

Дараа нь



Веб сайт (103.ub.gov.mn) facebook пэйж хуудас болон инстаграммд байгууллагын цаг үетэй холбоотой мэдээллийг 2026 онд байршуулж үйл ажиллагааны ил тод байдлыг "Шил ажиллагаа" системээр ханган ажиллаж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6, 8, 10 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэл хариуцагч байгууллагууд нь ил тод, нээлттэй байлгах 87 төрлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй ([shilen.gov.mn](http://shilen.gov.mn)) байршуулж 1-р улиралд 67,11% үнэлүүлсэн.

Д/д	Төрөл	Үзүүлэлт	2025 он	2026 он	Хувь
1	Вэб сайт	Хандалт	526015	555684	6.00%
2	Пэйж	Like	1169	8955	6 дахин өссөн
		Follower	2847	5146	80.7%
3	Инстаграмм	Like	190	370	94.7%
		Follower	300	359	19.6%




Байгууллагын цахим хуудаснуудад цаг үетэй холбоотой мэдээ мэдээлэл, зөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг цаг алдахгүй иргэдэд хүргэж ажилласан.

### ЗОРИЛТ 6.ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ, ЧАДАВХЖУУЛАХ

1.Ажлын байрны эмнэл зүйн сургалтыг ижил төст эрүүл мэндийн байгууллагуудтай /Өргөө, Хүрээ, Амгалан АГ, ХӨСҮТ, ЭХЭМҮТ, УНТЭ, ЦТЭ, УХТЭ-ээс мэргэшсэн эмч багш нараас /хамтран зохион байгуулах ажлыг 14 хоног тутамд хийсэн.

2.Шинэ ажилтныг чиглүүлэх, дадлагажуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, үнэлгээ авах, сайжруулах ажлыг зохион байгуулах тал дэр шинээр ажилд орсон 15 эмчид яаралтай тусламжийн цогц менежмент 5 өдрийн сургалтыг үндэсний сургагч багш Б.Тэгшжаргал, эх барих, дотор, хүүхдийн тусламж үйлчилгээ, чанарын албанаас тохиолдолд суурилсан сургалтыг 5 удаа, байгууллагын ЁЗХХ-ны дарга, эрсдэлийн менежер Д.Дариймаа 5 удаа сургалтыг орсон. Мөн 17 жолооч нарыг дагалдуулан, автомашины доторх тоног төхөөрөмж судалсан байдлаар үнэлгээ хийж ажилд авсан.

3.Ажилтанд ирсэн өргөдөл, гомдлыг улирлын ажил дүгнэлтэд тусгах, онцлох талархлыг цахим орчинд алдаршуулах зорилгоор сар бүрийн эмч, жолооч нарт ирсэн талархлыг сайтад байршуулан алдаршуулж байна. Дэлхийн эмч нарын өдрөөр хамгийн их дуудлагад явсан, хамгийн их хүүхэд үзсэн, хамгийн их тусламж үйлчилгээ үзүүлсэн гэх мэт хамгийн хамгийн шалгаруулж, нийтэд алдаршуулсан.



### ЗОРИЛТ 7. ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ХАРИЛЦАА ХАНДЛАГЫГ САЙЖРУУЛАХ чиглэлээр:

“Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулах “Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” аяныг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай амжилттай зохион байгуулсан. Аяны хүрээнд:

2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” аян зохион байгуулах тухай байгууллагын даргын А/75 дугаар тушаалын хүрээнд удирдамж, төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шагнал урамшууллыг тушаалаар баталж, шалгаруулж, Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан. 2025.01.03-ны өдрийн “Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” аян зохион байгуулах тухай байгууллагын даргын А/75 тушаалын хүрээнд удирдамж, төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шагнал урамшууллыг тушаалаар баталж, аяны удирдамж төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

Байгууллагын даргын А/75 дугаар тушаалын хүрээнд ажлын хэсгийн бүрэлдэхүүн аяны үр дүнг дүгнэж, ахлах эмч 3, дуудлагын эмч 3, оператор эмч, сувилагч, эмийн санч 3, жолооч 3, захиргаа, инженер техникийн ажилтан, аж ахуйн ажилтан 3, нийт 15 ажилтныг шалгаруулж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, урамшуулсан.

Байгууллагын хэмжээнд “Ёс зүйтэй харилцааг өөрөөсөө, хамт олноосоо эхэлье” 2 сарын аяны уриа гаргасан. Аяны хүрээнд салбар, ээлж тус бүр уриа гаргаж идэвхтэй оролцсон. Үүнд:



1. Хан-Уул салбарын уриа “НЭГ ЗҮРХ, НЭГ ХАМТ ОЛОН”,
2. Чингэлтэй салбарын уриа "НЭГ ДУУДЛАГА, НЭГ АМЬДРАЛ, НЭГ ҮЙЛДЭЛ, НЭГ ИТГЭЛ",
3. Баян-зүрх салбарын уриа "ЭЕРЭГ ХАНДЛАГА, ӨӨРИЙМСӨГ СЭТГЭЛ, ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАЖ, ТАНД ҮЙЛЧИЛНЭ",
4. Сонгино хайрхан салбарын уриа "ЗӨВХӨН БИ ХАНДЛАГЫГ ӨӨРЧИЛЖ, ХАМТЫН СОЁЛЫГ БҮТЭЭ",
5. Төв салбарын уриа “ЭЕЛДЭГ ХАРЬЦАА, ЭЕРЭГ ХАНДЛАГА”,
6. Хүүхдийг дуудлага хүлээн авах нэгдсэн нэгжийн уриа “ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭЭ-ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙГ БҮТЭЭ”,
7. Захиргаа, автобаазын уриа ““ЗӨВ СЭТГЭЛГЭЭГ БИД, ЗӨВ АЛХМЫГ ТА”
8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албанаас “ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙ” уриатайгаар байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлж, харилцаа хандлага, ажлын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, ёс зүй, сахилга хариуцлагаар манлайлагч нарыг тодруулах, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилготойгоор салбарын ээлж хамт олон төлөвлөгөө гарган, салбарын эмч нарын телеграмм группэд байрлуулан ажилласан.

Цахим орчинд болон салбар ээлж хамт олон дотроо бүгд уриагаа хэлж, байршуулсан. /Facebook. Instagram-д хуваалцав/.

Ёс зүйн аяны хүрээнд ажлын хувцсаа бүрэн өмсөж, зохих журмын дагуу энгэрийн тэмдгээ бүрэн зүүж хэвшсэн. Дуудлагын эмч нарын хувцаслалт, энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн байдал, мөн жолооч нарын хувцаслалт, энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн байдал болон хүүхдийн дуудлага хүлээн авах нэгдсэн нэгжийн хувцаслалт, энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн байдлыг кургаар харуулсан байдал



Мэндлэх ёс зүй, харилцаа хандлага, биеэ авч явж буй соёлыг байгууллагын ажилтан бүр эрхэмлэн ажиллаж байна.

Ажлын байран дээр болон бусад үед эелдэг харилцааг эрхэмлэн гомдол, саналгүй ажилласан. Хамт олны дунд дулаан уур амьсгал бүрдүүлэх зорилгоор өөрсдийн зургаар анимэйшн, хүүхэлдэйн баатрын дүр болгон хувиргаж сүлд модоо чимсэнб

Байгууллагын хэмжээнд харилцаа, хандлагатай холбоотой гомдол аяны хүрээнд гараагүй. Засгийн газрын 1111, 1800-1200 оператораас ийн талархал нийт 289 ирсэн. Үүнд:



“Түргэн тусламжийн эмч, жолооч нартаа хайрыг түгээцгээе” рийл видео хийж цахим пэйждээ байршуулсан. Ведиог түргэн тусламжийн баримтат киноноос хэсэгчлэн авч, үйлчлүүлэгч биед халддаг, эрсдэлийн талаар оруулж түргэн тусламжийн эмч жолооч нарын бодит байдлыг харуулсан контентыг эвлүүлж байршуулсан. Хандалтын тоо 1100 лайк, 247 шейр хийгдсэн байна.

Цахим орчинд /Facebook, Instagram / иргэдэд зориулсан богино хэмжээний зохиомж бичлэг байршуулан хамгийн олон лайк /143/, шейр /22/ хандалттай байна. Frame хийлгэж бэлтгэн зохион байгуулсан

Дуудлагын ачаалал багасгах /томуугийн/, яаралтай дуудлага болон хөнгөн өөрсдөө эмнэлэг явах боломжтой дуудлагыг иргэд олон нийтэд таниулах зорилгоор иргэдэд чиглэсэн контент бүтээж, сурталчилсан.




Манай оронд жил бүр улиралтай холбоотойгоор томуугийн өвчлөл 10-11-р сард ихэсдэг. Энэхүү өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хамгийн энгийн арга нь гар угаах, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгчээр гараа халдваргүйжүүлэх, агаарын сэлгэцэл хийх, дархлаа дэмжих, маск зүүх арга. Иймээс иргэдэд “Томуугийн өвчлөл, халдвар дамжих зам, урьдчилан сэргийлэх арга” сэдвийн хүрээнд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилготойгоор богино

НИЙТ



“Subdaa studio”-р дамжуулан байгууллага, ажлын онцлогоо сурталчлан олон нийтэд мэдээлэл хүргэж, шууд дамжуулсан. Үзэлт нийтshare ,35 Like-,128 үзэлт – 9000 давсан comment - .бүгд эерэг байв



Нийслэлийн түргэн тусламжийн төвийн ажлын онцлогийг танилцуулж иргэдэд анхан шатны ямар тусламж үзүүлэх талаар видео бичлэг хийж, иргэдэд сурталчилсан.



Жүжигчин Өскөтэй хамтарсан “Иргэдийг соён гэгээрүүлэх” рийл, “Тусламж үйлчилгээнд гарахад жолооч нар ажлын байрны бэлтгэлийг хэрхэн хангадаг талаар” рийл , “Ажлын хувцаслалт хэрхэн зөв, цэвэрхэн өмсөх санамж, “Таны зам тавьж өгсөн нэг хором нэг зүрхэнд амьдрал бэлэглэдэг. Зам тавьж өгсөнд баярлалаа” сэдэвт 60 ширхэг хуулга хийж дуудлагын автомашинуудад наасан.

“Дуудлагын эмч, жолоочийн нэг өдрийн үйл ажиллагаа” сэдэвт ажлын байраа сурталчлах, үйлчлүүлэгчийн ёс зүй ямар байх ёстой талаар мэдээ мэдээлэл хүргэх зорилгоор ажлын байран дээрх нэг өдрийн влог хийж, фэйсбүүк болон инстаграмм хуудсанд нийтэлж ажилласан.

Үүний үр дүнд цахим орчинд оруулсан рийл нь нийт 35,000 үзэлт хүрч, мэдээ мэдээлэл нь цахим орчинд түгээгдсэн.



Ахмад жолооч нарын ажлын талаарх сэтгэгдэл, дурсамж хуваалцсан бичлэгүүдийг авто баазын группт байршуулсан.

"Үгээрээ биш, үйлдлээрээ үлгэрлэе, хүндэлье" уриатай ажлын байран дээрх ёс зүйг харуулсан рийл хийж, телеграмм болон фэйсбүүкт байршуулсан.



Үйлчлүүлэгчдээс түргэн тусламжийн үйлчилгээний чанар, харилцаа хандлагын 8 асуултыг ГҮҮГЛ форм дээр боловсруулж, эмч нарт QR код болгон илгээж үнэлгээг хийсээр байна.



Асуултыг дурдвал:

Дуудлагаар ирсэн эмч тантай мэндэлсэн үү?


- Эмч танд үзлэг хийхдээ гараа халдваргүйжүүлсэн үү?
- Эмч таны үзлэг, эмчилгээний талаар ойлгомжтойгоор тайлбарлаж чиглүүлж өгсөн үү?
- Дуудлагын эмчийн гардан үйлдлийн ур чадварыг үнэлнэ үү
- Эмчилгээтэй холбоотой гарч болох хүндрэл, гаж нөлөөний талаар хэлж анхааруулсан
- Түргэн тусламжийн төвийн эмч тантай боловсон харьцсан уу ?
- Энэ удаад түргэн тусламжийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна ?



- Нийслэлийн түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулахад юунд анхаарах шаардлагатай талаар та саналаа бичнэ үү. Нийт ээлжийн эмч ажилчдын дунд 4 төрлийн асуулга бүхий хүснэгтээр /flip chart /үнэлгээ хийж хамгийн олон эможи авсан "Хамгийн хамгийн ёс зүйтэй эрүүл мэндийн ажилтан" эмч, сувилагч нарыг шалгаруулсан. Ахлах эмч, хамтран ажилладаг эмч нараас судалгаа, үнэлгээ авах зорилгоор 5 салбарт саналын хайрцаг аялууулсан.



Байгууллагын нийт ажилчдадаа ТАЛАРХЛЫН ЗАХИДЛЫГ цахим хаягаар 100% илгээсэн. Ажилтан бүрийн сэтгэл ханамж 100%, ажилчид өөрийн цахим хуудсандаа пост оруулах, стори оруулах хэлбэрээр талархлаа илэрхийлсэн.



Ёс зүйн аяны хүрэнд 2025.11.15-ны өдөр "Харилцан Адилгүй зан төлөвийг удирдах, үйлчлүүлэгчид анхны сэтгэгдлийг эергээр төрүүлэх сэдэвт сургалтыг Хан-уул салбарын эмч нарт Soft skills сургагч багш С.Буян-орших эмчийг урьж зохион байгуулав. Сургалтад дасгал ажил ажиллаж, бүлгийн ярилцлага хийв.



Дуудлага хүлээн авах нэгжийн нийт эмч сувилагч нарт “Эмнэлгийн ажилчдын ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулсан. 6 оператор эмч, 12 оператор сувилагч нийт 12 буюу 100% хамрагдсан.

Эрүүл мэндийн сайдын А/406 тоот “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” тушаалыг эмч нарт танилцуулан, цаашид ёс зүйн зөрчилтэй холбоотой алдаа, гомдол гаргахаас сэргийлж сургалт зохион байгуулсан.

“Ажлын байр нь дээрх ёс зүйтэй харилцааг төлөвшүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



“Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг үлгэрлэх нь” сэдэвт сургалтыг ажлын байран дээрээ Баянзүрх салбарын 1-р ээлж зохион зохион байгуулсан. Байгууллагын цахим хуудас болон эмч нарын iPad-ын дэлгэцэд эрүүл мэндийн сайдын А/406 тоот тушаалын 2 дугаар хавсралтын үйлчлүүлэгчийн үүрэг хэсгийг постер хэлбэрээр бэлтгэж байршуулж ажилласан. Цахим орчин



“Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” аяны үр дүн:

“Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” 2 сарын аяны хүрээнд байгууллагын ажилтан бүр ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлж, засгийн газрын 1111-ээс нийт 81 талархал авч, хамт олонч уур амьсгалыг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, иргэдэд эрүүл мэндийн боловсролыг түгээн дэлгэрүүллээ.

Өдөр бүхэн хамт олонч эерэг харилцаа, хандлага, инээмсэглэлийг өөртөө болон хамтран ажиглагсад, үйлчлүүлэгчдэд түгээж, ёс зүй эв эе, сахилга хариуцлагаар хамт олноо үлгэрлэсэн эрүүл мэндийн ажилтан, байгууллагын соёлыг хэвшүүлж байна.

Ажилтан бүр хамт олноо эергээр үлгэрлэж, эмнэлгийн мэргэжилтэн өөр хоорондын, эмнэлгийн мэргэжилтэн-үйлчлүүлэгч хоорондын харилцаа сайжирч, ажлын үр дүн, үнэлэмж дээшилсэн.

Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, иргэд хоорондын итгэлцэл, хүндлэл бий болж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан.

Ажилтнуудын ёс зүйн мэдлэг, хандлага сайжирч, байгууллагын дотоод уур амьсгалд эерэг өөрчлөлт гарсан.

Ажлын цаг барилт, дүрэмт хувцсыг иж бүрэн өмсөж 100% хэвшсэн.

Тусламж үйлчилгээнд ажиллаж байгаа автомашинууддаа санамж, стикер байршуулж, хувцаслалтаараа жигдэрч, ёс зүйн булан байгуулан, салбар бүрд саналын хайрцаг аялуулан инженер техникийн алба болон жолооч нарын талаарх саналыг авч дүгнэлээ.

Ёс зүйн буланд хууль, хэм хэмжээ, талархал, өмнөх сарын манлайлагчид, энэ сарын үзүүлэлт жолооч бүрийн нэрээр нийтэд ил тод байрлуулж өдөр тутам тэмдэглэл хөтөллөө.

Ёс зүйн аяны хүрээнд ёс зүйн чиглэлээр төлөвлөсөн олон талт ажлуудыг зохих түвшинд хэрэгжүүлж, байгууллагын ёс зүйн соёл, хариуцлага сайжирч бодит үр дүн гарсан гэж дүгнэж байна.

Цаашид:

Тус аяныг ЭМЯ, Эрүүл мэндийн сайдын нэрэмжит аян болгон жил бүр нэг удаа уламжлал болгон зохион байгуулах, ЭМЯ, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хэмжээнд байгууллагуудыг шалгаруулж, урамшуулах, шалгарсан байгууллагуудаас ёс зүйн чиглэлээр гадаадад улс орнуудад туршлага судлах уулзалт, семинар, сургалтад хамруулж байх саналтай байна.

**ЗОРИЛТ 8. ШИНЭ ТЕХНОЛОГИ, САЙН ТУРШЛАГА НЭВТРҮҮЛЭХ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫН ХҮРЭЭНД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ** чиглэлээр:

Салбар, ээлж, жолооч нарын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр сайн туршлагын аян өрнүүлж, сан үүсгэн бусдад сурталчилж, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах байгууллагын удирдамж, төлөвлөгөө ЭМТҮЧАБА-аас гаргаж, даргаар хянуулан, албад, салбар, ахлах эмч, нийт эмч бусад танилцуулан судлуулсан.

1.Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд хиймэл оюун ухааныг судлах, нэвтрүүлэх .Хиймэл оюун ухааны (AI) хэрэглээг ЗЦБ, ЭХО оношилгоонд нэвтрүүлэх талаар судлах, туршилт хийх, тохиолдлын хүрээнд үр дүнг тооцохоор 2026 оны 04 дүгээр сарын 08-аас дуудлагын эмч бүрийн iPad дээр Telegram суулгах нэвтэрч орох зааварчилгаа, зөвлөгөө өгч, Баянзүрх, Чингэлтэй салбар дээр очиж ажилласан. Мөн мобиком-той холбогдож мессеж хүлээн авах тохиргоог хийлгэсэн. Салбарын бүх iPad-ийг холбогдож зааварчилгаа өгч Telegram-ийн CHAT-AI\_BOT холбогдуулж оруулан, үе шаттай ажиллаж байна.

2026 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар хиймэл оюун ухаан ашиглан нийт 790 (total 790 request) хийгдэн, зүрхний цахилгаан бичлэгийн дүгнэлт бүртгэл үүсэж хадгалагдсан байна.



2.Эмнэлэг үйлчилгээний болон мэдээний хуудаснуудыг цахим болгох, хяналт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор шинээр “Карте” системд ахлах эмч нарын хөтөлдөг “Эмнэлэг үйлчилгээний мэдээллийн хуудас”-ыг цахим болгосноор хяналт хийх боломж бүрдсэн. Мэдээний хуудсыг “Нэмэлт тэмдэглэл” цэсээр орж бүртгэл үүсгэснээр хавсралт хэлбэрээр бичдэг талбар нэмсэн. Дуудлагын хуудас болон чанарын тайлан дотор нохой үргээгч, карбоксиметрээр үнэлгээ хийсэн сонголтыг оруулж, тайлан гардаг болсон. “Эмнэлэг үйлчилгээний мэдээллийн хуудас”-т нэмэлт тэмдэглэл бичдэг талбар нэмсэн. Чанарын тайлан дотор нохой үргээгч, карбоксиметр үзсэн гэсэн тайлан гардаг болсон.

3.Түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн GPS худалдана авалтын төслийн хүрээнд шинээр программ хангаж, төхөөрөмжтэй болсон.Үүнд:

- Түргэн тусламжийн дуудлагын хаяг байршил тодорхой болно,
- Дуудлага хүлээн авсан цаг, зарцуулсан цаг нарийвчлалтай бүртгэнэ,
- Дуудлагын автомашины хөдөлгөөн байршлыг хянана.

Үүний дүнд дуудлагын автомашин тухайн дуудлага өгсөн цэгт хүрсэн, ажиллагааг дууссан цагийг нарийвчлалтай бүртгэнэ,

4. “Судлаач эмч -2026” Дэлхийн эмч нарын өдөр угтсан 3 дугаар сарын 29-нд ОПБХ зохион байгуулж 13 илтгэлээр эмч судлаач нар идэвхтэй оролцсон. Судалгаа, бүтээлтэй болсон. Заримаас дурдахад:

- Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2024, 2025 онд бүртгэгдсэн дуудлагаас амиа хорлолт байж болзошгүй дуудлагад хийсэн үр дүнгийн судалгаа
- Архитай холбоотой дуудлагын тархвар зүй, эмнэл зүйн бүтэц, тусламжийн үр дүнгийн судалгаа
- НТТТ-өөр үйлчлүүлэгчдийн мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн бодисын хэрэглээг хянах нь
- Түргэн тусламжийн автомашины зам тээврийн осол, түүний шалтгаан ба бууруулах арга зам
- “Түргэн тусламжийн дуудлагын хүлээгдлийн хугацаанд нөлөөлөх хүчин зүйлсийн олон хувьсагчид регрессийн шинжилгээ”
- “Нийслэлийн түргэн тусламжийн төвд бүртгэгдсэн дуудлагуудын эрэмбийн зөрүү үүнээс үүдэж гарах эрсдэлүүд болон хэрхэн шийдвэрлэх талаарх судалгаа”
- “Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2024-2026 оны хооронд нүүрстөрөгчийн дан ислийн хордлого, эмнэл зүйн тохиолдол бүртгэлийн судалгаа гэх мэт олон чухал сэдвээр оролцсон.



ХЯНАСАН:  
ДАРГА

*(Handwritten signature in red ink)*

С.АРИУНБОЛД

ТАЙЛАН БИЧСЭН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
АЛБАНЫ МЕНЕЖЕР

*(Handwritten signature in black ink)*

З.ЭНХЦЭЦЭГ